



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2018 оны 10 сарын 16 өдөр

Дугаар 447

Улаанбаатар хот

Дорноговь аймгийн орон нутгийн өмчөөс  
2018 онд хувьчлах эд хөрөнгийн  
жагсаалтын тухай


Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг, 77 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Дорноговь аймгийн орон нутгийн өмчөөс 2018 онд хувьчлах эд хөрөнгийн жагсаалтыг хавсралтын ёсоор дэмжсүгэй.

2. Жагсаалтад заасан эд хөрөнгийг хувьчлах ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Орон сууц хувьчлах тухай хуулийн дагуу зохион байгуулж, дүнг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт 2018 оны 4 дүгээр улиралд багтаан танилцуулахыг Дорноговь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга С.Түмэнбаярт зөвлөсүгэй.

ДАРГА


ЗАХИРГАА ХУУЛЬ ЗҮЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА



Ц.НЯМ-ОСОР

Б. ГАВАА

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
 2018 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн дугаар  
 744 тогтоолын хавсралт



**Дорноговь аймгийн орон нутгийн өмчөөс 2018 онд хувьчлах эд хөрөнгийн жагсаалт**

д/д	Хувьчлах эд хөрөнгийн нэр	Эд хөрөнгийн олж авсан арга, хэлбэр, эрхийн акт, дугаар он сар өдөр	Байршил, Харьяалал	Хувьчлах эд хөрөнгийн үйл ажиллагааны чиглэл, үл хөдлөх хөрөнгийн зориулалт	Хувьчлагдах эд хөрөнгийн дүн /ААН бол нийт хөрөнгөөс өр төлбөр хассан дүнгээр, үл хөдлөх хөрөнгө бол балансын үлдэгдэл үнэ/ /мян.төг/	Хувьчлах хугацаа	Хувьчлах арга, хэлбэр
<b>Үл хөдлөх эд хөрөнгө</b>							
1	Орон сууцны барилга	УИХ-ын 1999 оны 29 дүгээр тогтоол	Айраг сум 4 дүгээр баг, Айраг сумы Засаг даргын Тамгын газар	Орон сууц	9,361,518.5	III-IV улиралд	Орон сууц хувьчлах тухай хуулийн дагуу

----- 000 -----